



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2021 оны 03 сарын 29 өдөр

Дугаар A/150

Арвайхээр

Г Шуурхай штабын ажиллах журам, бүтэц, Т
бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6-ын “б”, 29.3, Гамшигаас хамгаалах тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.4, 27.1.6, 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.8, Улсын Онцгой комиссын даргын 2021 оны 03 дугаар сарын 03-ны өдрийн “Шуурхай штабыг шинэчлэн байгуулах тухай” 22 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Коронавируст халдварт (КОВИД-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх хариу арга хэмжээг авч хэрэгжүүлэх чиглэлээр Засгийн газар, Улсын онцгой комиссоос гаргасан шийдвэрийг аймгийн хэмжээнд удирдан зохион байгуулах, хэрэгжилтийг хангуулах, хяналт тавих чиг үүрэг бүхий Шуурхай штабын ажиллах журмыг нэгдүгээр, Шуурхай штабын бүтцийг хоёрдугаар, шуурхай штабын бүрэлдэхүүнийг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Шуурхай штабт үүрэг гүйцэтгэж байгаа алба хаагчдын үндсэн ажил, үүргийг зохицуулж, цалин хөлс, урамшуулал, илүү цагийн нэмэгдэл хөлсийг хууль, тогтоомжийн дагуу тооцож олгохыг холбогдох байгууллагын төсвийн захирагч нарт даалгасугай.

3. Шуурхай штабын үйл ажиллагааг удирдлагаар хангаж, хяналт тавьж ажиллахыг аймгийн Шуурхай штаб (Онцгой байдлын газрын дарга, дэд хурандаа Д.Одонбаяр)-т үүрэг болгосугай.

4. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2021 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн A/145 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА

А.ИШДОРЖ



011100324